

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/012/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@auditgov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор: М.Пагамдулам Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn Аудитор: Б.Отгонцэцэг Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/039
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Хэрэгжээгүй төслийн урьдчилгаа төлбөрт төлсөн 35.8 сая төгрөгийг буцаан төлүүлээгүй;
- Төслийн ажлын тайланг хугацаа хоцроож ирүүлсэн байхад 22.2 сая төгрөгийн алданги тооцож аваагүй;
- Өмнөх онуудад гэрээ байгуулсан 4 төслийн урьдчилгаа санхүүжилтэд олгосон 114.6 сая төгрөгийн төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар арга хэмжээ аваагүй зэрэг

зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 10 дугаар зүйлийн 10.1.11, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дугаар заалттай нийцээгүй бөгөөд, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/347 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд нярайн гипотермийн аппарат, тархины бичлэгийн аппарат, азотын ислийн дамжуулалт ба хяналтын систем зэрэг нийт 1,285.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр бэлтгэж эх, хүүхдийн 5 эмнэлэгт хуваарилсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор Америкийн нэгдсэн улс, Бүгд найрамдах Турк улс, Бүгд найрамдах Солонгос улс, Бүгд найрамдах Хятад ард улс, Бүгд Найрамдах Энэтхэг улс зэрэг орны их дээд сургуулийн эмнэлэг болон тухайн улсын тэргүүлэх эмнэлгүүдтэй гэрээ байгуулж 6 эмнэлгийн 37 эмч, мэргэжилтэнг сургалтанд хамруулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2024 оны 2 дугаар сарын 28-ний өдрийн 78 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам”-ыг шинээр баталсан байна. Тус журмын 4.3-т заасны дагуу халдварт болон халдварт бус өвчин, орчны эрүүл мэнд, осол гэмтэл, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрүүл, аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх, эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах зэрэг төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулах, хяналт тавих ажлыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хариуцан зохион байгуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу

илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	618,541,993.00	1,967,546,000.00
34	УРЬДЧИЛГАА	618,541,993.00	1,967,546,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	618,541,993.00	1,967,546,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	618,541,993.00	1,967,546,000.00
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	7,482,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,482,000.00	-
413	Өглөг	7,482,000.00	-
4136	Бусад өглөг	7,482,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	7,482,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	611,059,993.00	1,967,546,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	611,059,993.00	1,967,546,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	611,059,993.00	1,967,546,000.00
51210	Өмнөх үеийн үр дүн	864,051,960.00	611,059,993.00
51220	Тайлант үеийн үр дүн	(252,991,967.00)	1,356,486,007.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	618,541,993.00	1,967,546,000.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,907,341,259.00	5,790,128,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,810,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,810,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,810,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	4,810,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,907,341,259.00	5,785,318,050.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,907,341,259.00	5,785,318,050.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,907,341,259.00	5,785,318,050.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,160,333,226.00	3,148,607,143.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,160,333,226.00	3,148,607,143.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,061,342,699.00	3,148,607,103.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,061,342,699.00	3,148,607,103.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,061,342,699.00	3,148,607,103.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,990,527.00	39.51
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,990,527.00	39.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,990,527.00	39.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(252,991,967.00)	2,641,521,007.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		1,285,035,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,285,035,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,285,035,000.00
6	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(252,991,967.00)	1,356,486,007.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,907,341,259.00	5,785,318,050.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,907,341,259.00	5,785,318,050.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,907,341,259.00	5,785,318,050.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,907,341,259.00	5,785,318,050.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,907,341,259.00	5,785,318,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,907,341,259.00	5,785,318,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,808,350,732.00	5,785,318,010.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,808,350,732.00	5,785,318,010.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,808,350,732.00	5,785,318,010.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,990,527.00	39.51
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,990,527.00	39.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,990,527.00	39.51
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	864,051,960.00	864,051,960.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	864,051,960.00	864,051,960.00
9	Тайлант үеийн үр дүн	(252,991,967.00)	(252,991,967.00)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	611,059,993.00	611,059,993.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	611,059,993.00	611,059,993.00
19	Тайлант үеийн үр дүн	1,356,486,007.00	1,356,486,007.00
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,967,546,000.00	1,967,546,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,810,000,000.00	5,785,318,010.49	4,024,681,989.51	59.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,810,000,000.00	5,785,318,010.49	4,024,681,989.51	59.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,810,000,000.00	5,785,318,010.49	4,024,681,989.51	59.0

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,810,000,000.00	5,785,318,010.49	4,024,681,989.51	59.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,810,000,000.00	5,785,318,010.49	4,024,681,989.51	59.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,810,000,000.00	5,785,318,010.49	4,024,681,989.51	59.0
1320	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,810,000,000.00	5,785,318,010.49	4,024,681,989.51	59.0
122005	Улсын төсвөөс санхүүжих	9,810,000,000.00	5,785,318,010.49	4,024,681,989.51	59.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 49.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
АШУУИС-ТЭШ-Анагаах ухааны хүрээлэнтэй 2021 онд байгуулсан гэрээний урьдчилгаа төлбөрт 49,235.4 мянган төгрөгийг олгож, ажлын тайланг үндэслэн гэрээг дүгнэж акт үйлдсэн боловч урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн байна.	1	49,235.4			1	49,235.4	1	49,235.4				
Дүн	1	49,235.4	-	-	1	49,235.4	1	49,235.4	-	-	-	-

3.2 Аудитаар нийт 179.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 136.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 42.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо/дүн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<p>Өмнөх онуудад гэрээ байгуулан хэрэгжсэн Бүдүүн шулуун гэдэсний бага гэмтэлтэй МЗН-д 37,350.0 мянган төгрөг, Ковер дизайн ХХК-д 25,200.0 мянган төгрөг, Монголын анагаах ухааны академи 31,010.0 мянган төгрөг, Жэй си ай монгол ТББ-д 21,000.0 мянган төгрөгийн 4 төслийн урьдчилгаа санхүүжилт 70.0 хувьд нийт 114,560.0 мянган төгрөг олгоод он дамжуулан авлагаар бүртгэж, жилийн эцэст тооцоо нийлж актаар баталгаажуулдаг, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар арга хэмжээ аваагүй хэвээр байна.</p>	1	114,560.0		1	114,560.0									
<p>Ай Ео Доктор ХХК-д 6,500.0 мянган төгрөгийн 2021 онд олгосон урьдчилгаа санхүүжилт нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, он дамжуулан авлагаар бүртгэсэн хэвээр, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, өмнөх аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.</p>	1	6,500.0	1	6,500.0										
<p>Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх төслийн хүрээнд МҮОНРТ-ийн 89,600.0 мянган төгрөгийн дүнтэй "Алаг амьдрал" төслийг сонгон шалгаруулж 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн №269 дугаар гэрээ байгуулж урьдчилгаа 70.0 хувьд 62,720.0 мянган төгрөг олгосон боловч уг төсөл хэрэгжээгүй, цаашид хэрэгжих боломжгүй гэж үзэж 26,910.0 мянган төгрөгийг МҮОНРТ-ийн "Эрүүл мэнд теле сэтгүүл" төслийн 30.0 хувийн санхүүжилтэд суутган тооцоог хааж, үлдэгдэл 35,810.0 мянган төгрөгийг буцааж аваагүй байна.</p>	1	35,810.0	1	35,810.0										
<p>Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх төслийн хүрээнд МҮОНР телевизийн "Эрүүл мэнд теле сэтгүүл" төслийг хэрэгжүүлэхээр 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн №270 дугаар гэрээг байгуулж, урьдчилгаа санхүүжилт 62,790.0 мянган төгрөг, төсөл хоорондын суутган тооцоогоор 26,910.0 мянган төгрөг нийт</p>	1	22,245.6		1	22,245.6									

89,700.0 мянган төгрөгийг бүрэн олгосон бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 248 хоногоор хугацаа хоцроож үйл ажиллагааны тайланг ирүүлж, гэрээг дүгнүүлсэн байхад 22,245.6 мянган төгрөгийн алданги тооцож аваагүй байна.												
Нийтийн эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр он дамжин хэрэгжсэн төслийн үр дүнг нэгтгэн тайлагнаагүй, дүгнэлт хийгээгүй, төслийн хэрэгжилтэд явцын хяналт хэрэгжүүлээгүй зэрэг дотоод хяналт хангалтгүй өмнөх оны аудитын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	-						1	-			
Дүн	5	179,115.6	2	42,310.0	2	136,805.6		1	-			

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотоод хяналттай холбоотой зөрчил						
ЭМДС-ийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх нийгмийн эрүүл мэндийн төсөл, арга хэмжээ, тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи худалдан авах төсөл, арга хэмжээг тайлант оны 1 дүгээр улиралд зохион байгуулахаар журамд заасан боловч мөрдөөгүй, 10 дугаар сард зохион байгуулж эхэлснээс шалтгаалан оройтож, шинээр хэрэгжиж эхлэх төслийн санхүүжилт 588,826.0 мянган төгрөгийг буцаан татуулсан зэргээс үзэхэд төслийн үр дүнг үнэлэх боломжгүй байна.	1	-			1	-
Дүн	1	-			1	-